# АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ” ЭЛС ХАЙРГАНЫ ХОЛИМГИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАН БЕТОН ЗУУРМАГ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

*Тусгай зөвшөөрлийн дугаар:* MV-65000035 (2022/001A)
*Регистрийн дугаар:3014231*

**Хянасан:**

БОАЖЯ-ны ХБОБНУГазрын мэргэжилтэн: ..........................................х.Дулмаа

Архангай аймгийн БОАЖГазрын мэргэжилтэн: .......................................Б.Солонго

**Биелэлтийг тайлагнасан:**

“Ашид бэхи” ХХК-ийн захирал:...............................................................П.Болортуяа

“Ашид бэхи” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн:.............................Н.Гончигмаа

2022 он

## Гарчиг


1. Оршил.....5
2. Төслийн товч танилцуулга.....5
3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....14
   3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....14
   3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....18
   3.3. Газрын хэвлий, ургамлан нөмрөгт сөрөг нөлөөллийг бууруулах төлөлвлөгөө болон биелэлт.....21
4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт .....28
5. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....31
6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....35
7. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....35
8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....35
9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....36
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөөний биелэлт.....37
11. Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ .....38
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....38
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....41
14. Дүгнэлт .....41


***Зургийн жагсаалт***


1. *Ордын байршил*
2. *Хотхоны тохижилт, мандалын цэцэг тарьсан байдал*
3. *Ажилчдын хотхон орчмын төлөв байдал*
4. *Офиссын байр*
5. *Ажилчдын гал тогоо*
6. *Ажилчдын ариун цэврийн байр*
7. *Бетон зуурмагийн үйлдвэр*
8. *Хайрга бутлуурын үйлдвэр*
9. *Зам усалгааны ажил хийгдэж буй байдал*
10. *Тоосжилтийг бууруулах зорилгоор хучилт хийж буй байдал*
11. *Тоосжилтыг бууруулах зорилгоор элс тээврийн машины ачаанд хучилт хийж буй байдал*

12. *Агаарын хэмжилт хийж буй байдал*
13. *Ундны ус болон, Ахуйн бохир уснаас дээж авч буй байдал*
14. *Ахуйн бохир ус соруулж буй байдал*
15. *Замын болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал*
16. *Шимт хөрсний овоолгоноос дээж авч буй байдал*
17. *Засварын талбайгаас хөрсний дээж авч байдал*
18. *Мод тарьж буй байдал 2022 оны 05 сар*
19. *Техникийн нөхөн сэргээлт хийх талбайн тойм зураг, тусгай зөвшөөрлийн талбайн хиллэлсэн байдал, координатын хамт*
20. *Техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнөх байдал*
21. *Техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал*
22. *Техникийн нөхөн сэргээлт дууссаны дараа*
23. *Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн талайн байршил*
24. *Эвдрэлд ороод орхигдсон талбайн төрх болон техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал*
25. *Техникийн нөхөн сэргээлтийн ажил дууссан байдал*
26. *Хог хаягдлаа ялган ангилах хогийн сав*
27. *Ажилчид сургалтанд хамрагдаж буй байдал*

***Хүснэгтийн жагсаалт***

1. *Тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицлууд*
2. *Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*
3. *Агаарын шинжилгээний хариу2022.10*
4. *Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*
5. *Үйлдвэрийн унд ахуйн ус 2022.05.18*
6. *Үйлдвэрийн унд ахуйн ус*
7. *Үйлдвэрийн унд ахуйн усны бактериологийн шинжилгээ*
8. *Газрын хэвлий, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*
9. *Шимт хөрсний овоолго хөрсний химийн үндсэн шинж*
10. *Ажилчдын хотхоны шимт хөрсний химийн үндсэн шинж 2022.05.17*
11. *Засварын талбайн хөрс 2022.10.06*
12. *Хөрсний бактерлогийн шинжилгээний хариу 2022.05.17*
13. *Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт*
14. *Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*
15. *Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт*
16. *Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*
17. *Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт*

***Хавсралтын жагсаалт***

1. *2022 оны Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр төлсөн баримт*
2. *Газар эзэмших гэрчилгээ*
3. *Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгүүлсэн баримт*
4. *2022.05-р сарын хөрсний агрохимийн шинжилгээний хариу*
5. *2022.05-р сарын хөрсний бактерлогийн шинжилгээний хариу*
6. *2022.10-р сарын хөрсний хүнд металлын шинжилгээний хариу*
7. *2022.10-р сарын шимт хөрсний агрохимийн шинжилгээний хариу*
8. *2022 оны ус ашиглах дүгнэлт*
9. *2022.05 сар ундны усны химийн шинжилгээний дүн*
10. *2022.05 сар ундны усны хими, бактерлогийн шинжилгээний дүн*
11. *2022.10 сар ундны усны химийн шинжилгээний дүн*
12. *2022.10-р сар ундны бактерлогийн шинжилгээний дүн*
13. *Худгын тоолуур, баталгаажуулалт, паспорт*
14. *Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан*
15. *Бохир ус соруулах, шугам сүлжээнд нийлүүлэх гэрээ*
16. *2022 оны Хог хаягдлын гэрээ*
17. *2022 он хог хаягдлын төлбөр төлсөн байримт, бохир ус соруулах төлбөр*
18. *Хайгуулын ажлын үр дүнгийн ЭБМЗ-ийн тушаал, дүгнэлт*
19. *ТЭЗҮ-ийн ЭБМЗ-ийн тушаал, дүгнэлт*
20. *Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл*
21. *Байгаль орчны төлөв байдлын суурь судалгааны тайлангийн нүүр*
22. *БОННҮ-ний тайлангийн нүүр*
23. *ТЭЗҮ-ийн тайлангийн нүүр*
24. *Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн акт*
25. *Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тайлангийн нүүр*
26. *Хуурай хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах болон үйлчилгээний үнэ төлбөрийг төвлөрүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах гэрээ*
27. *Худгийн усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ*
28. *АМНАТ-ын төлбөр төлсөн баримт*
29. *Байгаль орчны төлөвлөгөөний биелэлтйн дүгнэх хуудас*

## 1. ОРШИЛ

Манай компани нь байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн унаган төрхийг аль болох хадгалах, биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу өндөр түвшид хийж гүйцэтгэх бодлого баримталж, байгаль орчны бодлого зорилтод нийцсэн арга хэмжээнүүдийг авч, биелэлтийг хангаан ажилладаг. Үүнд:

- ✓ Байгаль орчны бохирдолтоос сэргийлэх, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авах зорилгоор байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хийлгүүлэх
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомж холбогдох дүрэм журам стандартыг дагаж ажиллах
- ✓ Олборлолт болон уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлэх хамаарна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь тус оны ашиглалтын үйл ажиллгаааны төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний заалтуудыг хангаан ажиллахад чиглэсэн болно.

## 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Дэнж” элс-хайрганы холимгийн орд нь Архангай хотоос 480 км, Архангай аймгаас зүүн урагш 5.0 км, Эрдэнэбулган сумаас зүүн урагш 2 км зайд оршино. Архангай аймаг нь нийт 55.3 мянган м$^2$ нутаг дэвсгэртэй, Хангайн уулархаг мужийн төв хэсэгт оршдог. Хангайн нурууны салбар уулс, ойт хээр, тал хээрийн бүсээс бүрддэг.Далайн түвшнээс дээш 2414 м өндөрт өргөгдсөн, уртраг 101027’, өргөрөг, 47028’, хамгийн өндөр цэг нь Харлагтайн сарьдаг 3539 м, хамгийн нам дор газар нь Орхон Тамирын бэлчир 1290 м. Нутгийн баруун,баруун өмнө,өмнө хэсэгт далайн түвшнээс дээш 2400-3500 метр өндөрт өргөгдсөн Хангайн нуруу болон түүний салбар уулс ,баруун хойд хэсэгт 3000 гаруй метрийн өндөр Тарвагатайн нуруу орших бөгөөд зүүн,зүүн хойд,зүүн өмнө талаараа далайн түвшнээс дээш 1000-1500 метрийн өндөртэй уулс,голын хөндий эзэлсэн тал хээртэй.

- ✓ Ордын нэр: “Дэнж”
- ✓ Засаг захиргаа: Архангай аймаг, Эрдэнэбулган сум
- ✓ Ашигт малтмалын үндсэн төрөл: Элс-хайрганы холимог
- ✓ Тусгай зөвшөөрлийн талбайн планшит: M-47-024

Тусгай зөвшөөрлийн талбайн нийт хэмжээ:

*Хүснэгт №1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицлууд*

| Д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **град** | **мин** | **сек** | **град** | **мин** | **Сек** |
| 1 | 101 | 30 | 59.29 | 47 | 26 | 58.55 |
| 2 | 101 | 30 | 45.43 | 47 | 26 | 55.13 |
| 3 | 101 | 30 | 45.43 | 47 | 27 | 22.0 |
| 4 | 101 | 31 | 18.89 | 47 | 27 | 22.0 |




*Зураг№1. Ордын байршил*

***Орд ашиглах тусгай зөвшөөрөл:*** Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших “Дэнж” нэртэй 37.41 га талбай бүхий ашигт малтмалын 2022/001А дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр “Ашид бэхи” ХХК-д олгосон байна.

***Ордын мэдээлэл***. Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 5-р багийн нутагт орших “Дэнж” элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглах төсөл нь 5 жилийн хугацаанд үргэлжлэх ба бодитой В боломжтой С зэрэглэлээр бодогдсон геологийн нөөц нь 561.57 мян.$м^3$ элс-хайрганы холимог байна.

Ордын магадласан (В’) үйлдвэрлэлийн нөөцөөр 356.12 мян.$м^3$ элс-хайрганы холимог олборлоно.

Тус ордын ил уурхайн хүчин чадлыг жилд 75.0 мян.$м^3$ элс-хайрганы холимог олборлохоор техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан байна.

Шимт хөрсийг хуулж стандартын дагуу овоолгод хураахаар тооцсон ба уурхайн хөрс хуулалт, элс-хайрганы олборлолтын хэмжээг тогтмол барьж ашиглалт явуулна.

***Хүний нөөц, ажлын горим***. Тус төсөл нь 1 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байна. Тус төслийн хүрээнд 28 хүн ажиллах ба 06 дугаар сараас 11 дүгээр сарыг дуустал тасралтгүй ажиллах бөгөөд жилд 180 хоног ажилласан. Дэнж элс-хайрганы холимгийн уурхай нь Цэцэрлэг хоттой ойр байрлах тул хүний нөөц, ажилчдын чадавхи өндөр, дэд бүтэц сайн хөгжсөн зэрэг давуу талуудтай байна. Иймд уурхайн ажилчид болон инженер техникийн ажилтныг Цэцэрлэг хотоос авч ажиллуулсан бөгөөд ажилчид уурхайд байрлаж ажиллахгүй.

Ордыг ил аргаар гадаад овоолго бүхий авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан.

***Уурхайн тоног төхөөрөмжүүд.*** ТЭЗҮ-д тусгагдсан уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдэд экскаватор Doosan-300 1ш, Howo-336 маркийн автосамосвал 3ш, XCMG ZL-50 маркийн утгуурт ачигч 2ш, усалгааны Daewoo цистерн-1ш байна.

***Бүтээгдэхүүн үйлдвэрлэл***. “Ашид бэхи” ХХК-ийн бүтээгдэхүүн үйлвэрлэлийн хэсэг нь бутлан ангилах хэсэг болон бетон зуурмагийн үйлдвэр гэсэн 2 хэсгээс бүрдэх бөгөөд Дэнж элс-хайрганы холимгийн ордоос 3.8 км-ын зайд байрлана. Бутлан ангилах хэсэг болон бетон зуурмагийн үйлдвэр нь нэг дор байрлаж байгаа бөгөөд Дэнж элс-хайрганы холимгийн ил уурхайгаас олборлосон элс, хайргыг автосамосвалаар тээвэрлэн бутлан ангилах хэсэгт түр овоолгод овоолж байна.

***Бутлан ангилах хэсэг.*** Бутлан ангилах хэсгийн эцсийн бүтээгдэхүүн нь ширхэгээр ангилсан элс, хайрга гарах бөгөөд бетон зуурмагийн үйлдвэрийн түүхий эд болгон ашиглаж М100-М350 маркийн бетон үйлдвэрлэж байна.



*Зураг №2. Хотхоны тохижилт, мандалын цэцэг тарьсан байдал*






*Зураг№ 3. Ажилчдын хотхон орчмын төлөв байдал*



*Зураг№4. Офиссын байр*







*Зураг№5. Ажилчдын гал тогоо*







*Зураг№6. Ажилчдын ариун цэврийн байр*

***Бетон зуурмагийн үйлдвэр.*** Жил бүр 03 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарыг дуустал хоногт 1 ээлжээр, жилд ажиллах хоног 155, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

2022 онд бэлтгэл ажил хойшлогдсоноор уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажил эхлээгүй тул 105 хоног ажилласан.

***Технологи ажиллагаа.*** Үйлдвэрлэлийн технологийн үндсэн зарчим нь урьдчилан тогтоосон орцын дагуу түүхий эдийг тугнуураар хэмжин бетон зуурагчид хольж зуурмаг бэлтгээд зориулалтын тээврийн хэрэгслээр зөөвөрлөн хэрэглэгчдэд хүргэж байна.

***Уурхайн хил хязгаар:*** Элс-хайрганы холимгийг олборлох уулын ажилд “Ашид бэхи” компанид байгаа экскаватор болон автосамосвалуудыг ашиглах бөгөөд нөөц тогтоогдсон блокуудын дунджаар ашигт давхаргын зузаан 3.4 м гүнд уулын ажлыг явуулахаар тооцооллоо. Ашиглалтын нөөцийг тусгай зөвшөөрлийн талбайн хилээр хязгаарлагдсан ил уурхайн хүрээгээр олборлоход уурхай нь 610 м урт, 270 м өргөн, 17.1 га талбайг эзлэх ба уурхай нь зүүн хойноос баруун урд зүгт чиглэлтэй сунаж тогтсон давхаргын суналын дагуу байрлана.

***Уулын ажлын календарь төлөвлөлт.*** ТЭЗҮ-д тусгаснаар Уурхайн хил хязгаараас нийт 7.85 мян.м$^3$ хөрс хуулж, 562.96 мян.м$^3$ элс-хайрганы холимог олборлоход хөрс хуулалтын коэффициент дунджаар 0.014 м$^3$/м$^3$ болж байна.

2022 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 78.15 мян.м$^3$ элс-хайрга олборлон боловсруулна. Ил уурхайн сар бүрийн олборлолт 15.63 мян.м$^3$ элс-хайрга олборлохоор тусгасан. Ил уурхайн бэлтгэл ажил 5-р сараас эхлэсэн ба хөрс хуулалт, элс-хайрганы олборлолтын ажлыг 5-р сарын 20-с 11-р сарыг дуустал ажиллахаар төлөвлөсөн бөгөөд энэ жилийн хувьд 78.15 мян.м$^3$ элс-хайрга олборлон боловсруулна.

2022 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу 78.15 мян.м$^3$ элс-хайрга олборлох байснаас 17.01 мян.м$^3$ олборлосон.





*Зураг №7. Бетон зуурмагийн үйлдвэр*



*Зураг №8. Хайрга бутлуурын үйлдвэр*

# 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Ашид бэхи”ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй.

## *3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

*Хүснэгт №2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

| № | Төлөвлөгөө | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| **1.** | Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалттай авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах | Компанийн менежер | Үйлдвэр уурхай хоорондох замыг сайжруулан засаж тэмдэг тэмдэглэгээ хийсэн. |
| **2.** | Зам арчилгааны зардал | | |
| **3.** | Олборлолтын үед тоосжилт ихээр үүсэхээс сэргийлж тогтмол усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах | | Зам усалгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байсан. |
| **4.** | Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх | | Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг хийлгэсэн ба шинжилгээний дүнг хавсаргав. |
| **5.** | Хүнд механизмууд, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг байнга хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх | | 250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн тос, маслыг сольж байсан. Тээврийн хэрэгслийн төлбөр, татварыг бүрэн төлж ажилласан. |
| **6.** | Тоосжилтыг бууруулах зорилгоор бүтээгдэхүүнд хучилт хийж хамгаалах. | | Уурхайгаас үйлдвэр явах технологийн замд элс тээврийн машины ачаанд хучилт хийх, бутлуураас гарсан бүтээгдэхүүнийг хучих замаар тоосжилтыг бууруулах арга хэмжээ авч байсан. |



*Зураг №9. Зам усалгааны ажил хийгдэж буй байдал*





*Зураг№10. Тоосжилтийг бууруулах зорилгоор хучилт хийж буй байдал*




*Зураг№11. Тоосжилтыг бууруулах зорилгоор элс тээврийн машины ачаанд хучилт хийж буй байдал*



*Зураг №12. Агаарын хэмжилт хийж буй байдал*

*Хүснэгт №3. Агаарын шинжилгээний хариу 2022.10*

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Хүхэрлэг хий мг/м$^3$ | Азотын давхар исэл мг/м$^3$ | Нийт тоосонцорын агууламж /TSP/ мг/м$^3$ | Дуу чимээ /ДБА/ |
|---|---|---|---|---|---|---|
| *1* | Карьер | X/05 | 0.021 | 0.040 | 0.056 | 35 |
| *2* | Ажилчдын хотхон | X/05 | 0.013 | 0.015 | 0.085 | 25 |
| *3* | Тээврийн зам | X/05 | 0.119 | 0.010 | 0.082 | 46 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016** | | | ***0.450*** | ***0.200*** | ***0.500*** | ***60*** |

3 цэгт хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосонцорын агууламж, дуу чимээг хэмжиж үзэхэд стандарт үзүүлэлтээс давсан үзүүлэлт байхгүй байна.

### *3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

Байгаль орчны нөлөөлллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, БОМТөлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ундны ус, ахуйн бохир уснаас дээж авч тус тус лабораторид шинжлүүлэв.

*Хүснэгт №4 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

| № | Төлөвлөгөө | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх | Байгаль орчны мэргэжилтэн | Шинжилгээний хариу шалгуур үзүүлэлт нь хавсралтад тусгагдав. |
| 2. | Унд ахуйн усанд эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахин ажиллах | | Бүсэд мөрдөх журмыг боловсруулан, нийт ажилчдад танилцуулсан. |
| 3. | Уурхайн унд ахуйд хэрэглэж буй худагт тоолуур тавих | Байгаль орчны мэргэжилтэн | Уст цэгтээ буюу худагтаа баталгаат тоолуур тавиулсан. |
| 4. | Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх, орчны бохирдол үүсэхээс сэргийлж хуримтлуулах, бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулж цэвэршүүлж ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн усалгаанд ашиглах | Байгаль орчны мэргэжилтэн | Ахуйн бохир усыг орон нутагтайгаа гэрээ байгуулан тусгай зориулалтын машинаар соруулж орон нутгийн төвлөрсөн байгууламжид хүргүүлж байна. |
| 5. | Шатах тослох материал алдагдах үед урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | Байгаль орчны мэргэжилтэн | Шатах тослох материалаас алдагдах үед авах зааварчилгаа гарган ажилчдад сургалт зохион байгуулсан. |





*Зураг№13. Ундны ус болон, Ахуйн бохир уснаас дээж авч буй байдал*

*Хүснэгт №5. Үйлдвэрийн унд ахуйн ус 2022.05.18*

| **Анион** | **1дм3-д байгаа** | | | **Катион** | **1дм3-д байгаа** | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | Мг-экв | Мг-экв% | | мг | Мг-экв | Мг-экв% |
| **$Cl1^-$** | 15.6 | 0.44 | 9.7 | $Na^++K^+$ | 39.5 | 1.72 | 37.9 |
| **$SO_4^{--}$** | 9.0 | 0.19 | 4.1 | $Ca^{++}$ | 36.9 | 1.84 | 40.5 |
| **$NO_2^-$** | 0.0 | 0.00 | 0.0 | $Mg^{++}$ | 11.9 | 0.98 | 21.6 |
| **$NO_3^-$** | 10.0 | 0.16 | 3.6 | $NH_4^+$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| **$CO_3$** | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| **$HCO_3^-$** | 228.8 | 3.75 | 82.6 | $Fe^{+++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| **Дүн** | 263.4 | 4.54 | 100.0 | Дүн | 88.3 | 4.54 | 100.0 |

$HCO_3^-$ -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 237.3мг/дм$^3$
Анион катионуудын нийлбэр: 351.7мг/дм$^3$
Ерөнхий хатуулаг: 2.82мг-экв/дм$^3$
pH 7.49, EC:379 ms/см, TDS: 210 ppm, Исэлдэх чанар 3.20мг/дм$^3$
Физик шинж чанар: тунгалаг: 30см, өнгө: үгүй, үнэр: үгүй, амт: үгүй, тунадас: үгүй, булингаршил: 1.78NTU

*Хүснэгт №6. Үйлдвэрийн унд ахуйн ус*

| № | Үзүүлэлт | Шинжлэх аргын стандарт | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ | 2022.10.06 |
|---|---|---|---|---|
| 1 | pH-Усны орчин | MNS ISO 10523-2001 | **6.5-8.5** | 7.31 |
| 2 | Цахилгаан дамжуулах чанар, µS/cm | MNS ISO 7888:1999 | **<1.0** | 0.32 |
| 3 | Ерөнхий хатуулаг, мг-экв/л | MNS ISO 6059:2005 | **<7.0** | 3 |
| 4 | Кальци, ($Ca^{2+}$) мг/л | MNS 1097:1970 | **<100.0** | 37.68 |
| 5 | Магни, ($Mg^{2+}$) мг/л | Тооцооны арга | **<30.0** | 13.62 |
| 6 | Карбонат, ($CO_3^-$) мг/л | MNS ISO 9963-1:2005 | **-** | 0.00 |
| 7 | Хлорид, ($Cl^-$) мг/л | MNS ISO 9297:2005 | **350.0** | 12.76 |
| 8 | Гидрокарбонат, ($HCO_3^-$) мг/л | MNS ISO 9963-1:2005 | **-** | 220 |
| 9 | Нитрит, ($NO_2^-$) мг/л | MNS 4431-2005 | **<1.0** | 0.01 |
| 10 | Нитрат, ($NO_3$), мг/л | MNS ISO 7890-3:2001 | **<50.0** | 1.82 |
| 11 | Аммони, ($NH_4$), мг/л | MNS 1097:1970 | **<1.5** | 0.07 |
| 12 | Төмөр, ($Fe^{3+}$) мг/л | MNS 4430:2005 | **<0.3** | 0.01 |
| 13 | Сульфат, ($SO_4^{2-}$) , мг/л | MNS 6271:2011 | **<500.0** | 9.17 |
| 14 | Хуурай үлдэгдэл, мг/л | MNS 4423:1997 | **<1000.0** | 193 |
| 15 | Натри + Кали, ($Na^+$, $K^+$) | Тооцооны арга | **<200** | 27.15 |

Дүгнэлт:

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальци-магнийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

*Хүснэгт №7. Үйлдвэрийн унд ахуйн усны бактериологийн шинжилгээ*

| № | Шинжилсэн үзүүлэлт, хэмжих нэгж | Шинжилгээний аргын стандарт | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ | 2022.05.17 |
|---|---|---|---|---|
| **1.** | Нийт нянгийн тоо | MNS ISO 6222:1998 | <100 | 2 |
| **2.** | Гэдэсний бүлгийн савханцар(E.coli) | MNS ISO 9308:1:1998 | илрэхгүй | илрээгүй |
| **3.** | Гэдэсний булчингийн эмзэг үүсгэгч нян (Samonella) | MNS 6479:1999 | илрэхгүй | илрээгүй |

| № | Шинжилсэн үзүүлэлт, хэмжих нэгж | Шинжилгээний аргын стандарт | Зөвшөөрөгд өх дээд хэмжээ | 2022.10.06 |
|---|---|---|---|---|
| 1. | Нийт нянгийн тоо | MNS ISO 6222:1998 | <100 | 90 |
| 2. | Гэдэсний бүлгийн савханцар(E.coli) | MNS ISO 9308:1:1998 | илрэхгүй | илрээгүй |
| 3. | Гэдэсний булчингийн эмзэг үүсгэгч нян (Samonella) | MNS 6479:1999 | илрэхгүй | илрээгүй |

Үр дүн: Цэвэр усны микробиологийн шинжилгээний үр ундны ус нь стандарт хэмжээнд байна.





*Зураг№14. Ахуйн бохир ус соруулж буй байдал*

### *3.3. Газрын хэвлий, ургамлан нөмрөгт сөрөг нөлөөллийг бууруулах төлөлвлөгөө болон биелэлт*

*Хүснэгт №8. Газрын хэвлий, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

| № | Төлөвлөгөө | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Газар эзэмших гэрээгээ Эрдэнэбулган сумын ЗД-тай байгуулах, төлбөрөө төлөх | Компанийн захирал | Газрын гэрчилгээг хавсаргав. |
| 2. | Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явуулахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах, сайжруулах. | Байгаль орчны мэргэжилтэн | Технологийн замдаа тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан. |
| 3. | "Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага" MNS 5916 :2008 | Байгаль орчны мэргэжилтэн | Шимт хөрсийг стандартын дагуу хуулах, хадгалах ажлыг зохион байгуулсан. |
| 4. | Хөрс-агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох | Байгаль орчны мэргэжилтэн | Шимт хөрсний овоолгоос дээж авч лабораторид шинжлүүлсэн. |
| 5. | Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах | Байгаль орчны мэргэжилтэн | Хамгаалах талбайг бэлтгэн, асгаралтын үед шаардагдах элс, шингээгч материалуудыг ойр байршуулсан. |
| 6. | Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу газар ашиглагч, эзэмшигч нь 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын хянан баталгаан заавал хамрагдах ёстой байдаг. | Компанийн захирал | 2022.05.17-нд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мэргэжлийн эрх бүхий "Эко хайрхан"ХХК-аар гэрээ байгуулан ажлаа хийлгүүлсэн. |
| 7. | Цөлжилтөөс хамгаалах ойн тухай хуулийн дагуу уурхайн ашиглалтын талбайд тарьсан модоо арчлах хамгаалах | Компанийн захирал | Үйлдвэрийн ажилчдын хотхонд 5 төрлийн 250ш модыг тарж арчилгаа хийж байна. |
| 8. | "Ар ус Ундарга" ХХК-тай байгуулсан гэрээг үндэслэн ахуйн бохир соруулах талбайн хөрс орчимд ариутгалын ажил хийх. | Байгаль орчны мэргэжилтэн | Ахуйн бохир соруулах орчмын талбайн хөрсийг сар бүр ариутгах ажлын дотоодоо зохион байгуулж байсан. |



*Зураг№15. Замын болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал*

Хөрснөөс дээж авахдаа бид талбайн ерөнхий шинжийг илтгэж чадахуйц цэгүүдээс зохих маршрутын дагуу явж дээж авдаг. Бид засварын талбай, үржил шимт хөрснөөс дээж авч “Ханлаб”-д хүнд металлын шинжилгээ, Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид хөрсний химийн ерөнхий шинжилгээнд өгч шинжлүүлэв. Тус шинжилгээгээр хөрсний ялзмаг, хөрсний pH, хүнд металлуудыг үзүүлж биологийн нөхөн сэргээлт хийхэд анхаарах зүйлс болон хөрсний ялзмаг, нөхөн сэргээлтэнд бордоо ашиглах зэрэг зөвлөмжийг оруулав.



*Зураг №16. Шимт хөрсний овоолгоноос дээж авч буй байдал*

*Хүснэгт №9. Шимт хөрсний овоолго хөрсний химийн үндсэн шинж*

| Дээжний дугаар | pH $H_2O$ (1:2:5) | $CaCO_3$ % | Ялзмаг % | $EC_{2.5}$ dS/m | Хөдөлгөөнт мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | $P_2O_5$ | $K_2O$ |
| шимт хөрс | 6.50 | 0.00 | 2.547 | 0.067 | 1.81 | 21.7 |

| Дээжний дугаар | Ширхэгийн хэмжээ, (% мм-ээр) | | |
|---|---|---|---|
| | Элс (2-0.05 мм) | Тоос (0,05-0,002 мм) | Шавар (<0.002 мм) |
| шимт хөрс | 59.9 | 30.7 | 9.3 |

**Товч дүгнэлт:** Шимт хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн түвшин дундаж гарсан байна.

Бид хуулийн дагуу газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажилаа мэргэжлийн эрх бүхий “Эко хайрхан”ХХК-аар талбайн хэмжээнд хийлгүүлсэн. Тус ажлын явцад ажилчдын хотхоны шимт хөрснөөс дээж авч “Green lab” хөрс судлалын лабораторид шинжлүүлсэн.

*Хүснэгт №10. Ажилчдын хотхоны шимт хөрсний химийн үндсэн шинж 2022.05.17*

| Дээжний дугаар | pH $H_2O$ (1:2:5) | $CaCO_3$ % | Ялзмаг % | $EC_{2.5}$ dS/m | Солилцох суурь, мг-экв/100гр | | | Хөдөлгөөнт мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ca+Mg | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| шимт хөрс 0-10 | 8.78 | 0.02 | 3.60 | 0.031 | 19.2 | 18.0 | 1.2 | 2.8 | 25 |
| Шимт хөрс 10-20 | 8.95 | 0.01 | 2.41 | 0.029 | 21.2 | 19.4 | 1.8 | 2.2 | 21 |
| Шимт хөрс 20-40 | 9.03 | 0.02 | 0.65 | 0.047 | 16.8 | 13.6 | 3.2 | 0.7 | 10 |

| Дээжний дугаар | Ширхэгийн хэмжээ, (% мм-ээр) | | |
|---|---|---|---|
| | Элс (2-0.05 мм) | Тоос (0,05-0,002 мм) | Шавар (<0.002 мм) |
| шимт хөрс | 59.9 | 30.7 | 9.3 |

**Товч дүгнэлт:** Химийн шинжилгээний дүнг харахад хөрсний урвалын орчин хүчтэй шүлтлэг, өнгөн хэсэг карбонатгүй, 20см доош дунд зэрэг карбонатжсан, ялзмагийн агууламж дунд зэрэг боловч 20см дош эрс багасна., сул давсархаг, хөдөлгөөнт фосфорын болон калийн агууламж 0-20см-т дундаж, түүнээс доош багасна. Хөрсний үржил шимийн түвшин дундаж.

Хөрсний өнгөн давхрага дээр хүнд металлын шинжилгээ хийлгэсэн бөгөөд шинжилгээний дүнгээр “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу одоогоор хөрсний бохирдол үүсээгүй байна гэж гарсан.

Үйлдвэрийн засварын талбайн хөрс, шимт хөрснөөс дээж авсан. Засварын талбайд үйлдвэр, уурхайн машин техникт ашигласан тос, тосолгооны аюултай хаягдал гарах тос

тосолгооны материал алдагдсанаар газрын хөрсөнд их хэмжээний бохирдолт үүсгэх эрсдэлтэй байдаг.




*Зураг№ 17. Засварын талбайгаас хөрсний дээж авч байдал*

*Хүснэгт №11. Засварын талбайн хөрс 2022.10.06*

| | ЭЛЕМЕНТ, % | | | | | ЭЛЕМЕНТ, мг/кг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Na** | **Ca** | **Mg** | **K** | **Fe$_{нийт}$** | **As** | **Ba*** | **Be** | **Bi** | **Cd** |
| **Засварын талбайн хөрс** | 2.10 | 1.06 | 0.35 | 2.13 | 2.48 | 6.47 | 467.3 | <5.0 | <10.0 | <1.0 |
| ***Хүлцэх агууламж MNS5850:2019*** | - | - | - | - | - | *50.00* | - | - | - | *3.00* |
| | ЭЛЕМЕНТ, мг/кг | | | | | | | | | |
| | **Co** | **Cr** | **Cu** | **La** | **Li** | **Mn** | **Mo** | **Ni** | **P** | **Pb** |
| **Засварын талбайн хөрс** | 10.73 | 34.71 | 12.04 | 10.05 | 16.35 | 428.4 | <5.0 | 15.68 | 327.6 | 20.54 |
| ***Хүлцэх агууламж MNS5850:2019*** | *50.00* | *150.0* | *100.0* | - | - | - | *5.0* | *150.0* | - | *100.0* |
| | ЭЛЕМЕНТ, мг/кг | | | | | | | | | |
| | **Sb** | **Se** | **Sr*** | **Ti** | **V** | **Y** | **Zn** | **Zr*** | | |
| **Засварын талбайн хөрс** | <10.0 | <5.0 | 217.1 | 2346 | 50.25 | 8.28 | 56.05 | 49.91 | | |
| ***Хүлцэх агууламж MNS5850:2019*** | - | *10.00* | *800.0* | - | *150.0* | - | *300.0* | - | | |

**Товч дүгнэлт:** Засварын талбайнуудын хөрс хүнд металлаар бохирдох магадлалтай байдаг. Талбайгаас дээж авч “Ханлаб” лабораторид өгч хүнд металлын шинжилгээнд 28 элемент шинжлүүлсэн бөгөөд стандарт хэмээнээс давсан үзүүлэлт гараагүй. (хортой агууламжийг уул уурхайн бүсэд бохирдуулах бодисын хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй адил утгаар мөрдлөг болгож тооцоход)

Үйлдвэрийн ажилчдын хотохоны бие засах газрын хөрснөөс дээж авч хөрс судлалын “Green lab” хөрс судлалын лабораторид бактерологийн шинжилгээ хийлгүүлсэн.

*Хүснэгт№12. Хөрсний бактерлогийн шинжилгээний хариу 2022.05.17*

| № | Дээжний нэр | Шинжилгээний нэр | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг |
|---|---|---|---|---|
| 1 | Дээж 2 | Гэдэсний нянгийн тоо | $1.3*10^5$ | Бохирдолгүй |
| 2 | | Гэдэсний савханцарын титр (E.coli) | 1 | Цэвэр |
| 3 | | Clostridium perfringens | <0.1 | Цэвэр |

**Товч дүгнэлт:** Шинжилгээгээр 1гр хөрсний дээжинд бактерийн нийт тоо байх ёстой хязгаарт илэрсэн бөгөөд Clostridium perfringens, гэдэсний савханцарын титр (E.coli) илрээгүй учраас бохирдолгүй хөрсний ангилалд хамаарч байна.

**Орчноо тохижуулж мод тарьсан:**

Цөлжилтөөс хамгаалах ойн тухай хуулийн дагуу, “Тэр бум мод” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн орчинд орон нутгаас 5 төрлийн 250 ш модыг суулгаж арчилгаа, усалгааны ажлыг гүйцэтгэж байна. Мод сонгон авахдаа 2-3 настай Нохойн хошуу 30ш, Голт бор 30ш , Гүйлс 30ш, Үрэл 30ш, Гацуур 10ш, Алимны мод 10ш, Интоор 10ш, Агч 50ш, Үхрийн нүд 50ш орон нутгийн мод үржүүлгийн газраас худалдаж авсан.

Орчноо сайхан харагдуулах өнгө үзэмж сайтай навчаараа, жимсээрээ, мөчрөөрөө, цэцгээрээ гоёдог гоёлын болон жимсний моднуудыг сонгосон. Суулгахдаа нутгийн иргэдийг болон ажилчдаа оролцуулан мэргэжлийн хүний зөвлөгөөтэйгээр мод хоорондын зай, мөр хоорондын зай, мод тарих тогооны хэмжээ, усалгаа арчилгаа гэх мэтээр ажилчдад давхар мод тарих бодит сургалт болсоноороо илүү давуу талбай байлаа.

Цаашдын арчилгаа чухал байдаг учраас мод болон хашаан доторх зүлгээ арчлах услах ажил дээр тусгайлан цэцэрлэгч томилон ажиллуулж байна.





*Зураг№18. Мод тарьж буй байдал 2022 оны 05 сар*

## 4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт хэрэгжих Дэнж элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглах төслийн ТЭЗҮ-д 6 дахь жилд нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөсөн байна. 2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийн ажил тусгагдаагүй байна.

**2022 онд хийгдсэн нөхөн сэргээлтийн ажил:**

Дэнж уурхайн карьерийн залгаа эвдрэлд ороод орхигдсон талбайд орчны хог цэвэрлэгээний ажил хийгдэж, 0.47 га буюу 17.01 мян.м$^3$ элс-хайрга олборлосон.

| Д.д | Координат | |
|---|---|---|
| 1 | 690049.30 | 5258877.15 |
| 2 | 690036.85 | 5258847.39 |
| 3 | 690023.77 | 5258843.57 |
| 4 | 690014.97 | 5258837.10 |
| 5 | 690014.13 | 5258830.90 |
| 6 | 690014.91 | 5258825.98 |
| 7 | 690013.20 | 5258820.67 |
| 8 | 690001.95 | 5258818.45 |
| 9 | 689990.53 | 5258821.79 |
| 10 | 689986.20 | 5258825.97 |
| 11 | 689984.61 | 5258836.12 |
| 12 | 689972.32 | 5258846.85 |
| 13 | 689973.19 | 5258852.44 |
| 14 | 689964.42 | 5258857.71 |
| 15 | 689962.45 | 5258866.92 |
| 16 | 689972.45 | 5258887.95 |
| 17 | 689979.31 | 5258902.69 |
| 18 | 690010.27 | 5258904.62 |
| 19 | 690021.14 | 5258892.62 |
| 20 | 690036.26 | 5258885.07 |
| 21 | 690047.86 | 5258882.98 |



*Зураг№19. Олборлолтын талбайн тойм зураг, тусгай зөвшөөрлийн талбайн хиллэлсэн байдал, координатын хамт*



*Зураг№20. Эвдрэлд ороод орхигдсон талбайн өмнөх байдал*



*Зураг№21. Ажлын явц хийж буй байдал*



*Зураг№22. Техникийн нөхөн сэргээлт дууссаны дараа*

# 5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт №13. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт*

| № | Төлөвлөгөө | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Архангай аймгийн Их Тамир сумын саналын дагуу хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосны улмаас эвдэрч орхигдсон талбайд ТНС-н ажлыг хийж гүйцэтгэх | Компанийн захирал | Архангай аймгийн Их тамир сумын нутагт эвдрэлд ороод орхигдсон байсан 1,08 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгсөн. |



*Зураг№23. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн талайн байршил*







*Зураг№24. Эвдрэлд ороод орхигдсон талбайн төрх болон техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал*







*Зураг№25. Техникийн нөхөн сэргээлтийн ажил дууссан байдал*

## 6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй.

## 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны олборлолтын явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

## 8. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд осол эрсдэлгүй ажилласан байна. Хөдөлмөр аюулгүй байдлын сургалт, өдөр тутмын зааварчилгааг ХАБ хариуцсан мэргэжилтэн өгч байгаа билээ.

*ХүснэгтNo14. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Төлөвлөгөө | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хяналт тавьж байх /ажил эхлэхийн өмнө/ | Механик инженер | ХАБ инженер болон механик инженер өглөө бүр ажил эхлэхийн өмнө техникийн үзлэг хийж аюулгүй байдлыг ханган ажиллаж байсан. |
| 2. | Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах | Компанийн захирал | Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын сургалтын зохион байгуулж байсан. |
| 3. | Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх | ХАБ инженер | Аюулгүй ажилагааны зааварчилгааг ажил эхлэхийн өмнө өдөр бүр ХАБ инженер өгч аюулгүй байдлаа ханган ажиллаж ирсэн. |
| 4. | Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах | ХАБ инженер | Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулан орон нутгийн онцгой байдлын газраар дүгнэлт гаргуулсан. |
| 5. | Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох | ХАБ инженер | Салхи шуурга болон бороотой үед ажлыг түр зогсоож байсан. |

## 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдлыг Эрдэнэбулган сумтай гэрээ байгуулан тээвэрлүүлсэн. /Төлбөр төлсөн баримт хавсаргав/ Мөн байгальд шууд хаягдах хаягдлын хэмжээг багасгахын тулд эх үүсвэр дээр нь ялган ангилалт хийх хогийн савыг уурхайн хотхон байрлуулан, ялган ангилалт хийж, ажилчдад хог хаягдлын хор уршиг болон ялган ангилалтын үр ашгийн талаарх сургалт мэдээллийг өгч байсан.

Манай компанийн бас нэг уриа бол цэвэр орчинд ажиллаж амьдрахыг мөрдлөг болгодог. Тийм ч учраас зөвхөн өөрийн талбайгаар зогсохгүй ойр орчмын хог хаягдалдаа дарагдсан байсан газрын бүх л ахуйн хатуу хог хаягдал болоод малын сэг зэмийг цэвэрлэх ажлыг нэгдсэн журмаар зохион байгуулсан бөгөөд энэ ажилдаа нутгийн иргэдийг татан оролцуулж цалин хөлсийг нь олгож ажилласан.

Мөн үйлдвэрлэл явуулж байгаа орчноо цэвэр цэмцгэр байлгах нь байгаль орчин төдийгүй хүний эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангах бөгөөд тав тухтай амьдрах орчыг давхар давхар бүрдүүлж өгдөг ач холбогдотой билээ.

*Хүснэгт №15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт*

| № | Хийгдэх ажил | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Хог хаягдлын төлбөрөө төлөх | Компанийн захирал | Төлбөр төлсөн баримт хавсаргав. |
| 2. | Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан тээвэрлүүлэх | Байгаль орчны мэргэжилтэн | Орон нутагтай байгуулсан гэрээг хавсралтаа оруулав. |
| 3. | Ахуйн хатуу хог хаягдал хаях сав байрлуулах | Байгаль орчны мэргэжилтэн | Хог хаягдлаа төрөлжүүлэн ангилах зориулалтын хогийн савыг байрлуулав. Зураг хастралтаар оруулав. |
| 4. | Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашаа барих | Байгаль орчны мэргэжилтэн | Хог хаядал орчинд тархахаас урьдчилан сэргийлж хатуу хог хаягдлаа газар дээр нь ялган ангилах ажил хийж байна. |



*Зураг№26. Хог хаягдлаа ялган ангилах хогийн сав*

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус оны 6 дугаар сард “Ногоон эко мандала” ХХК, 10 дугаар сард “Газарчандмань” ХХК-аар хийлгүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж мөн агаар дахь тоосжилтын хэмжээ болон дуу, чимээ, харьцангуй чийгшил зэрэг үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийсэн.

*Хүснэгт№16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

| Хяналт шинжил-гээний дээж | Хяналт шинжилгээний үзүүлэлт | Хяналт шинжилгээ явуулах хугацаа | Хяналт шинжилгээ явуулах байршил | Биелэлт |
|---|---|---|---|---|
| **Агаар** | Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, $NO_2$. $SO_2$ CO -ын агууламж, дуу чимээ | Жилд 1 удаа | Уурхайн карьер, Уурхайн зам, Ажилчдын хотхон | Байгаль орчны зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Газарчандмань”ХХК-тай гэрээ байгуулан хяналт шинжилгээний ажлаа хийлгүүлсэн. |
| **Ус** | Ажилчдын унд ахуйд ашигладаг усыг бактериологи болон ундны усны ерөнхий шаардлага, цэврийн болон бохирын нуурын усыг гадаргын ус болон хүнд | Жил бүрийн 5 болон 8 дугаар сарuудад | Унд ахуйн усны гүний худаг, цэврийн болон бохирын нуур | Байгаль орчны зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Газарчандмань”ХХК-тай гэрээ байгуулан хяналт шинжилгээний ажлаа хийлгүүлсэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | металлын шинжилгээнд өгөх | | | |
| **Хөрс** | Хөрсний агрохими болон хүнд металлын шинжилгээ хийлгэх мөн тухайн газар дээр хөрсний температур хэмжих | Жилд 1-2 удаа | Уурхай - Овоолго - Кемп Хүнд металл: -ажилчдын ариун цэврийн байгууламж | Байгаль орчны зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Газарчандмань”ХХК-тай гэрээ байгуулан хяналт шинжилгээний ажлаа хийлгүүлсэн. Мөн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааний ажлыг “Эко хайрхан”ХХК-р гүйцэтгүүлэхдээ хөрсний зарим дээжээ шинжлүүлсэн. |

## 11. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Аймгийн Засаг даргын албан шаардлага ирээгүй болно.

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

*Хүснэгт №17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт*

| № | Хийгдэх ажил | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх | Компанийн захирал Байгаль орчны мэргэжилтэн | Байгаль орчны бодлого хөтөлбөр, хяналт шинжилгээ хийх журам, хог хаягдлын цуглуулах, хадгалах ажлын тухай заавар журмуудыг захирлаар батлуулж, ажилчдад танилцуулан дагаж мөрдөн ажиллаж байна. |
| 2. | Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах | | Байгаль орчныг хамгаалах ажилд /Хог хаягдал цэвэрлэх, мод тарих /нийт ажилчидтаа хамтран ажилласан. |
| 3. | Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах | | Хяналт шинжилгээний ажлын хүрээнд “Аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй” сэдвээр ажилчдын дунд сургалт зохион байгуулж ажилчдынхаа экологийн боловсролд хувь нэмэр оруулсан. |
| 4. | БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах | | Тухайн жилийн БОМТБТайланг журмын дагуу боловсруулан орон нутгийн БОА-д хүргүүлсэн. |

Хяналт шинжилгээний ажлын хүрээнд “Аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй” сэдвээр ажилчдын дунд сургалт зохион байгуулж ажилчдынхаа эрүүл ахуйн боловсролд хувь нэмэр оруулсан. Сургалтын нэг хэсгээс доор оруулав.





*Зураг№27. Ажилчид сургалтанд хамрагдаж буй байдал*

## 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил болон нөлөөлөлд өртөх оршин суугчдад тайлан тавих ажил хийгдэх шаардлагагүй.

### БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

*Хүснэгт №11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал*

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Нийт зардал, төгрөг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 350,000 |
| 2 | Тэрбум мод төслийн хүрээнд мод бут тарих | 1,000,000 |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 500,000 |
| 4 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 150,000 |
| 5 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 120,000 |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 1,122,000 |
| **Нийт** | | **3,242,000** |

## 14. ДҮГНЭЛТ

2022 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 78.15 мян.$м^3$ элс-хайрга олборлон боловсруулах байснаас 0.47 га талбайд уулын ажил явагдсан ба 17.01 мян.$м^3$ элс-хайрга олборлосон.

2022 оны БОМТөлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй боловч манай компани уурхайн карьерын хажууд байрлах хуучин эвдрэлд ороод оригдсон газрын хог хаягдлыг цэвэрлэж, техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд Архангай аймгийн Их тамир сумын нутагт эвдрэлд ороод орхигдсон 1.08 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгсөн.

2022 оны байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг 6, 10-р сард байгаль орчны үнэлгээ, зөвөлгөөний эрх бүхий байгууллага “Ногоон эко мандала” ХХК, “Газарчандмань” ХХК-аар хийлгэн гүйцэтгүүллээ.

Агаар орчныг хамгаалах ажлын хүрээнд агаар дахь тоосонцор, хүхэрлэг хий, азотын давхар ислийн хэмжээг MNS 4585:2016 стандарттай харьцуулав. Стандартаас давсан үзүүлэлт байгаагүй. Тоосжилтоос хамгаалах үүднээс замын усалгаа, зам сайжруулах, тэмдэг тэмдэглэээ байрлуулах, элс хайргандаа хучилт хийх замаар тоосжилтыг бууруулах ажлуудыг зохион байгуулсан.

Усан орчныг хамгаалах ажлын хүрээнд үйлдвэрийн ундны уснаас авсан дээжийг Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид 2022,05,17 өгч шинжлүүлсэн бөгөөд бактерлогийн шинжилгээний дүнгээр стандарт хэмжээнд байна. Ундны усны дээжийг Шинжлэх ухааны академи Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, “Монгол ус”ТӨҮГ-т усны шинжилгээний лабораторид тус тус анион катионы химийн шинжилгээнд өгсөн. Ундны ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальци-магнийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна. Мөн мэргэжлийн байгууллагаар худаг гаргуулж паспортжуулан, баталгаат тоолуур тавиулах ажлыг гүйцэтгэсэн.

“Дэлхийн усны нөөцийн өнөөгийн нөхцөл байдал болоод ус дахин ашиглах хэрэгцээ шаардлага” сэдвээр ажилчдын дунд сургалт зохион байгуулж ажилчдынхаа экологийн боловсролд хувь нэмэр оруулсан.

